



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/167/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Утас: 99862066 Цахим хаяг: peakomaudit@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Т.УРАНЧИМЭГ ТАНАА

2022.02.25 № СЭА-2022/167-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	18,384,310.44	22,449,769.30
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31210	Төгрөг	0.00	0.00
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
33	АВЛАГА	0.00	175,142.82
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	175,142.82
33500	Бусад авлага	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	18,384,310.44	22,274,626.48
35400	Хангамжийн материал	18,384,310.44	22,274,626.48
35410	Бичиг хэргийн материал	0.00	9,900.00
35420	Аж ахуйн материал	7,016,895.00	6,285,405.00
35460	Хүнсний материал	0.00	455,800.00
35470	Бусад хангамжийн материал	11,367,415.44	15,523,521.48
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	459,144,228.23	453,077,898.24
37320	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	459,144,228.23	453,077,898.24
39200	Биет хөрөнгө	444,847,328.23	439,093,498.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	(29,630,337.00)	(49,870,846.92)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	40,266,436.00	36,349,534.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,714,449.74)	(13,482,544.25)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,719,696.00	21,643,630.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,924,284.03)	(5,701,335.51)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,267,935.00	3,267,935.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,273,420.00)	(2,248,626.04)
39300	Биет бус хөрөнгө	14,296,900.00	13,984,399.96
39302	Хуримтлагдсан элэгдэл	(687,500.00)	(1,000,000.04)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	477,528,538.67	475,527,667.54
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	20,366,789.00	19,357,729.84
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	20,366,789.00	19,357,729.84
41200	Богино хугацаат зээлийн өглөг	0.00	0.00
41210	Төгрөг	0.00	0.00
41300	Өглөг	20,366,789.00	19,357,729.84
41360	Бусад өглөг	20,366,789.00	19,357,729.84
41361	Байгууллагад төлөх өглөг	20,366,789.00	19,357,729.84
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
42100	Урт хугацаат үнэт цаас	0.00	0.00
42200	Урт хугацаат зээл	0.00	0.00
42210	Төгрөг	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	457,161,749.67	456,169,937.70
51	Засгийн газрын хувь оролцоо	457,161,749.67	456,169,937.70
51200	Хуримтлагдсан үр дүн	(70,044,125.04)	(71,035,937.01)
51210	Өмнөх үеийн үр дүн	(68,698,623.50)	(70,044,125.0)
51220	Тайлант үеийн үр дүн	(1,345,501.54)	(991,811.97)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	477,528,538.67	475,527,667.54

2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	477,191,530.00	464,422,550.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,416,530.00	22,146,350.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,416,530.00	22,146,350.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	11,238,014.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	11,238,014.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	15,348,590.00	5,610,790.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	67,940.00	5,297,546.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	461,775,000.00	442,276,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	399,381,900.00	382,913,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	399,381,900.00	382,913,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	276,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	276,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,393,100.00	59,086,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,393,100.00	59,086,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	478,469,091.54	464,435,315.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	478,469,091.54	464,435,315.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	436,384,042.54	436,237,374.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,285,501.00	281,740,732.18
210101	Үндсэн цалин	202,943,910.00	202,166,337.18
210102	Нэмэгдэл	61,396,820.00	58,747,016.00
210104	Урамшуулал	20,944,771.00	20,827,379.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,733,285.00	36,804,624.00
210201	Тэтгэврийн даатгал	24,541,766.00	25,787,462.40
210202	Тэтгэмжийн даатгал	2,836,900.00	2,792,400.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,327,600.00	2,350,812.57
210204	Ажилгүйдлийн даатгал	552,700.00	529,359.23
210205	Эрүүл мэндийн даатгал	5,474,319.00	5,344,589.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,811,553.00	57,532,340.84
210301	Гэрэл, цахилгаан	4,122,254.00	4,013,051.00
210302	Түлш, халаалт	45,897,699.00	48,973,044.84
210303	Цэвэр, бохир ус	3,791,600.00	4,546,245.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,158,965.54	3,661,983.96
210401	Бичиг хэрэг	137,800.00	271,100.00
210402	Тээвэр, шатахуун	145,200.00	12,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,150,000.00	896,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	889,100.00	950,400.00
210408	Бараа материал акталсны зардал	836,865.54	1,532,083.96
2105	Нормативт зардал	24,279,370.00	20,936,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	87,900.00	106,700.00
210502	Хоол, хүнс	23,842,170.00	20,389,850.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	349,300.00	440,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,498,500.00	1,362,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	25,000.00
210604	Урсгал засвар	3,498,500.00	1,337,100.00
2107	Томилолт, зочны зардал	12,000.00	140,000.00

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	12,000.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	665,700.00	1,291,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	341,700.00	643,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,939,168.00	32,767,943.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	467,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,247,000.00	2,977,810.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,225,168.00	29,790,133.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,085,049.00	28,197,941.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,085,049.00	28,197,941.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,085,049.00	28,197,941.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-1,277,561.54	-12,765.97
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	67,940.00	979,046.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	67,940.00	979,046.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-1,345,501.54	-991,811.97
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	461,775,000.00	442,276,200.00
110	Орлогын албан татвар	0.00	0.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	0.00	0.00
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	461,775,000.00	442,276,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	399,381,900.00	382,913,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	399,381,900.00	382,913,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	276,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	276,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,393,100.00	59,086,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,393,100.00	59,086,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	458,225,010.00	435,401,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	458,225,010.00	435,401,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	416,139,961.00	407,203,259.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	285,280,725.00	281,915,875.00
210101	Үндсэн цалин	183,892,325.00	199,271,086.00
210102	Нэмэгдэл	80,687,900.00	61,845,949.00
210104	Урамшуулал	20,700,500.00	20,798,840.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,733,286.00	36,804,624.00
210201	Тэтгэврийн даатгал	24,541,767.00	25,787,462.40
210202	Тэтгэмжийн даатгал	2,836,900.00	2,792,400.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,327,600.00	2,350,812.57
210204	Ажилгүйдлийн даатгал	552,700.00	529,359.23
210205	Эрүүл мэндийн даатгал	5,474,319.00	5,344,589.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	61,563,900.00	58,563,900.00
210301	Гэрэл, цахилгаан	4,122,254.00	4,013,051.00
210302	Түлш, халаалт	53,650,046.00	50,004,604.00
210303	Цэвэр, бохир ус	3,791,600.00	4,546,245.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,781,400.00	2,415,300.00
210401	Бичиг хэрэг	137,800.00	239,000.00
210402	Тээвэр, шатахуун	145,200.00	12,000.00
210404	Ном, хэвлэл	100,300.00	60,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,150,000.00	896,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,248,100.00	1,207,900.00
2105	Нормативт зардал	23,890,450.00	22,053,150.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	87,900.00	106,700.00
210502	Хоол, хүнс	22,878,350.00	20,823,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	924,200.00	1,123,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,498,500.00	1,362,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	25,000.00
210604	Урсгал засвар	3,498,500.00	1,337,100.00

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2107	Томилолт, зочны зардал	12,000.00	140,000.00
210702	Дотоод албан томилолт	12,000.00	140,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	665,700.00	1,291,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	341,700.00	643,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,714,000.00	2,657,310.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	495,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,219,000.00	2,657,310.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,085,049.00	28,197,941.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	42,085,049.00	28,197,941.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,085,049.00	28,197,941.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,549,990.00	6,875,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,549,990.00	6,875,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,549,990.00	6,875,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,549,990.00	6,875,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,549,990.00	6,875,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-3,549,990.00	-6,875,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	229,741,717.00	299,380,604.71	(70,615,070.50)	458,507,251.21
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,916,447.00	1,916,447.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	229,741,717.00	299,380,604.71	(68,698,623.50)	460,423,698.21
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(1,916,447.00)	-	(1,916,447.00)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,345,501.54)	(1,345,501.54)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	229,741,717.00	297,464,157.71	(70,044,125.04)	457,161,749.67
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	229,741,717.00	297,464,157.71	(70,044,125.04)	457,161,749.67

12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	229,741,717.00	297,464,157.71	(70,044,125.04)	457,161,749.67
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(991,811.97)	(991,811.97)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	229,741,717.00	297,464,157.71	(71,035,937.01)	456,169,937.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	442,000,200.0	413,802,259.0	28,197,941.0	93.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	442,000,200.0	413,802,259.0	28,197,941.0	93.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	442,000,200.0	413,802,259.0	28,197,941.0	93.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,771,400.0	281,915,875.0	14,855,525.0	95.0
210101	Үндсэн цалин	210,891,400.0	199,271,086.0	11,620,314.0	94.5
210102	Нэмэгдэл	65,018,900.0	61,845,949.0	3,172,951.0	95.1
210104	Урамшуулал	20,861,100.0	20,798,840.0	62,260.0	99.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,732,000.0	36,804,624.0	1,927,376.0	95.0
210201	Тэтгэврийн даатгал	26,861,200.0	25,787,462.4	1,073,737.6	96.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,967,700.0	2,792,400.2	175,299.8	94.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,374,200.0	2,350,812.6	23,387.4	99.0
210204	Ажилгүйдлийн даатгал	593,500.0	529,359.2	64,140.8	89.2
210205	Эрүүл мэндийн даатгал	5,935,400.0	5,344,589.6	590,810.4	90.0
210301	Гэрэл, цахилгаан	9,526,800.0	4,013,051.0	5,513,749.0	42.1
210302	Түлш, халаалт	40,451,600.0	50,004,604.0	(9,553,004.0)	123.6
210303	Цэвэр, бохир ус	8,585,500.0	4,546,245.0	4,039,255.0	53.0
210401	Бичиг хэрэг	167,400.0	239,000.0	(71,600.0)	142.8
210402	Тээвэр, шатахуун	220,500.0	12,000.0	208,500.0	5.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	585,600.0	-	585,600.0	0.0
210404	Ном, хэвлэл	121,700.0	60,000.0	61,700.0	49.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	742,700.0	620,400.0	122,300.0	83.5

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	301,400.0	1,207,900.0	(906,500.0)	400.8
2105	Нормативт зардал	33,112,300.0	22,053,150.0	11,059,150.0	66.6
210502	Хоол, хүнс	31,882,300.0	20,823,150.0	11,059,150.0	65.3
2107	Томилолт, зочны зардал	171,100.0	140,000.0	31,100.0	81.8
210702	Дотоод албан томилолт	171,100.0	140,000.0	31,100.0	81.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,615,700.0	1,291,000.0	324,700.0	79.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	643,700.0	643,000.0	700.0	99.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.0	648,000.0	324,000.0	66.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,657,400.0	2,657,310.0	90.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,657,400.0	2,657,310.0	90.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		276,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		276,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		276,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		276,000.00
210401	Бичиг хэрэг		
210402	Тээвэр, шатахуун		
210406	Хог хаягдал, хортон шавьж		276,000.00
2105	Нормативт зардал		0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		0
210502	Хоол, хүнс		0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		
210601	Багаж, техник, хэрэгсэл		0
210602	Тавилга		0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		
2132	Бусад урсгал шилжүүлэг		0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		0
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		276,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		276,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		276,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн /цаашид Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэг/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Пийк-Ом Аудит ХХК-ны аудитор А.Батболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэг нь “ Бага насны хүүхдийн бүх талын хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад багш, цэцэрлэг, эцэг, эх олон нийтийн байгууллагын хамтын ажиллагаа оролцоог хангаж хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулна” гэсэн зорилго тавин ажиллаж байна.

Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны боловсрол олгох

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой.
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”

- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйл.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн .

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 683,794.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 6,837.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 4,786.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,001.0 мянган төгрөгөөр

буюу 3.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээр үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-
Авлага	-	175.1	175.1
Бараа материал	18,384.3	22,274.6	3,890.3
Үндсэн хөрөнгө	459,144.2	453,077.8	(6,066.4)
Нийт хөрөнгийн дүн	477,528.5	475,527.5	(2,001.0)
Өр төлбөр	20,366.7	19,357.7	(1,009.0)
Эздийн өмч	457,161.7	456,169.0	(992.7)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	477,528.4	475,526.7	(2,001.0)

Тайлант онд авлага дансны үлдэгдэл 175.1 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын хөнгөлөлтийн тооцооны зөрүүгээс үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 22,274.6 мянган төгрөг болж 3,890.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 27,101.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар “Жаргалтай хүүхдийн өрөө” ТББ-аас 3,500.0 мянга, Иргэн Цэрэнгээс 568.0 мянган төгрөгийн орны даавуу гудас, БСГ-аас 766.7 мянган төгрөгийн тоглоом, 73,6 мянган төгрөгийн эм боох материал, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 164,5 мянган төгрөгийн халуун хэмжигчийг тус тус үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 25,998.1 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 525,381.2 мянган төгрөг болж өмнөх оноос 4,000.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 6,875.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авсан болон Сайхан сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор 19,716.7 мянган төгрөгийн хөрөнгө акталж, цаашид ашиглах боломжтой 5,610.7 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунган үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 19,357.7 мянган төгрөг болж өмнөх оноос 1,009.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэхүү өр нь 2018 оноос хуримтлагдсан талбайн жишиг үнийг төсөвт дутуу тусгуулж, батлуулсан зөрүүнээс үүссэн дулааны өр төлбөртэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 456,169.0 мянган төгрөг болж 992.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 464,422.5 мянган төгрөг болж өмнөх оноос 12,768.9 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан нь 9,737.8 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого, урсгал үйл ажиллагааны

санхүүжилтийн орлого 3,306.3 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 464,435.7 мянган төгрөг болж өмнөх оноос 14,033.7 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан нь Ковид-19 цар тахлын улмаас цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 3,544.7 мянган төгрөгөөр, тогтмол зардал 3,342.7 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 473,705.2 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 22,104.0 мянган төгрөгөөр өсгөн, **495,809.2** мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 495,809.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 443,722.4 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 52,086.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 382,913.4 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 59,088.8 мянган төгрөг, нийт 442,000.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **413,802.2** мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 28,198.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 413,802.2 мянган төгрөг буюу 83.5 хувьтай тайлагнагдсан нь цалин урамшууллын зардлыг 14,855.1 мянга, норматив зардлыг 11,059.1 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас цэцэрлэгийн ариутгалын санхүүжилтэд 276.0 мянган төгрөг олгосныг Мөнх Ариун Сэлэнгэ ХХК-аар ариутгал хийлгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%” гэж заасан боловч цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

3.7.2 БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай” тушаалын нэгдүгээр хавсралт “Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 132 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээлэл мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэгт 495,809.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 413,802.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 16.5 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 618.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 төлбөрийн акт, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1 зөвлөмж өгснөөс төлбөрийн актыг барагдуулж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	2	618.2	2	618.2	100
Зөвлөмж	1	0	0	0	0
Нийт дүн	3	618.2	2	618.2	66.66

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 89,828.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,310.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 175.1 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 88,342.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн өмнөх үеийн үр дүнгийн тайлан 60.9 мянган төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- Мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны урсгал зардлын дүнг 1,250.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлсэн алдааг аудитын явцад залрууллаа.

4.2 Албан шаардлага

1.Төсвийг зохистой удирдаагүй, авлага, өр төлбөрийн тооцоог хянан баталгаажуулаагүйн улмаас тайлант онд ХХОАТ-ын 175.1 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.1 Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1.1 Илрүүлэлт: Тайлант онд 88,342.7 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу

бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 1 дүгээр цэцэрлэг	4	89,828.7	2	1,310.9			1	175.1	1	88,342.7